

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2010 оны 5 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 146

Улаанбаатар хот

Г “Нэт капитал ББСБ” ХХК-д банк бус санхүүгийн г
итгэлцлийн үйлчилгээний үйл ажиллагаа эрхлэх
тусгай зөвшөөрөл нэмж олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.2.1, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 9.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 186 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам”-ын 5.3 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Нэт капитал ББСБ” ХХК-д банк бус санхүүгийн итгэлцлийн үйлчилгээний үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл нэмж олгосугай.

2. Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллах, тусгай зөвшөөрөл шинээр нэмж олгосонтой холбогдуулан тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад зохих тэмдэглэгээ хийлгэж, Улсын бүртгэлийн ерөнхий газарт холбогдох бүртгэлийг хийлгэсэн гэрчилгээ, ББСБ-ын дүрмийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар болон итгэлцлийн үйлчилгээнд мөрдөх журмын эх хувийг 2010 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн дотор Хороонд ирүүлэхийг “Нэт капитал ББСБ” ХХК /Н.Ундрах/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бичил санхүүгийн газар /Н.Оюунчимэг/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН